



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 119

Номгон

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн  
аймгийн салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажиллах журмын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Салбар зөвлөлийн дарга: Г.Батжаргал-Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Б.Одгэрэл-Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн

Гишүүд: Б.Бямбачимэг-Номуналай ахлах сургуулийн монгол хэл, бичиг уран зохиолын багш

Л.Отгонбаяр-Эрдэм ахлах сургуулийн монгол хэл, бичиг уран зохиолын багш

Ж.Балжинням-Эрдэнэмандал ахлах сургуулийн монгол хэл, бичиг уран зохиолын багш

Л.Бумтирмаа-Богд сумын сургуулийн захирал

О.Болормаа-Баянцагаан сумын сургуулийн сургалтын менежер

Г.Сандагдорж-Ахмаагийн багш, "Их үндэстний бичиг" ТББ-ын тэргүүн

2.Монгол хэлний тухай хууль болон бусад хууль тогтоомж, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага арга зүйгээр хангаж, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.25 дугаар хэсэгт заасан "Хос бичигтэн аймаг" болс хөтөлбөрийг боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийг аймгийн салбар зөвлөл /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.





БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 190

Номгон

Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн  
гурван талт салбар хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.1, 138.3, 138.5 дахь заалт, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны дүрмийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Салбар хорооны дарга: Б.Батсуурь - Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Д.Сосорбурам-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ц.Дашцэрэн-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Г.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Д.Ихбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

С.Байгалмаа-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Амарсанаа-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

В.Гүрсэд-Аймгийн үйлдвэрчний холбооны дарга

Ц.Дорж-Аймгийн үйлдвэрчний холбооны дэд дарга

П.Уранчимэг-Аймгийн үйлдвэрчний холбооны хөдөлмөрийн улсын байцаагч

Б.Мөнхбат-Аймгийн үйлдвэрчний холбооны хяналтын хорооны дарга

Э.Цэрэндээжид-Аймгийн үйлдвэрчний холбооны тэргүүлэгч

Б.Бат-Ирээдүй-Баянхонгор сумын төлөөлөл бөгөөд аймгийн үйлдвэрчний холбооны тэргүүлэгч

Т.Бат-Очир -Аймгийн ажил олгогч эздийн холбооны дарга

Н.Норовсүрэн-Аймгийн ажил олгогч эздийн холбооны менежер

Д.Батбаяр -Аймгийн ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч

И.Батдэлгэр-Сүлдэн тэнгэр хоршооны дарга, аймгийн ажил олгогч эздийн холбооны гишүүн

Ц.Алтангэрэл -Номундалай ахлах сургуулийн захирал

Б.Батбаяр -Төрийн банкны захирал

2.Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хорооны дүрмийн дагуу ажиллаж, хэлэлцээрийн биелэлтийг хагас, бүтэн жилээр хэлэлцэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Монголын хөдөлмөр нийгмийн зөвшлийн үндэсний хороонд тус тус тайлагнахыг салбар хорооны дарга /Б.Батсуурь/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.





БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 101

Номгон

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2014 оны 105 дугаар  
тогтоолыг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Тогтоолын хөсрөлтад өөрчлөлт оруулах тухай" 105 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



116199



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 122

Номгон

Г

Г

Ээлжит хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IY хуралдааныг 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдөр буюу Билгийн тооллын өвлийн дунд сарын шинийн 03-ны шар морь өдрийн 10 цагт Баянхонгор сумын төвд зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1.1. Аймгийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөөллийг батлах тухай

1.2. Аймгийн 2017 оны төсвийн төслийг батлах тухай

1.3. Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай /Зохион байгуулалтын асуудал/

2. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, асуудлыг Тэргүүлэгчдээр урьдчилан хэлэлцүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.





БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 123

Номгон

Г Бусдын эд хөрөнгийг хулгайлах  
гэмт хэргээс урьдчилан сэргийлэх  
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлтэй хамтран аймгийн хэмжээнд үр дүнтэй ажил зохион байгуулсугай.

2. Баянхонгор аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх "Хөршийн холбоо" журмыг боловсруулан батлуулж, сумдад болон багуудад "Хөршийн холбоо"-г байгуулан ажиллуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Сүүлийн 5 жилийн хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн судалгаанд үндэслэн бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах арга хэмжээг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа /Б.Оюутболд/-д даалгасугай.

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан үндэслэл журмын дагуу энэ төрлийн гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Уранчимэг/, Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа /Б.Оюутболд/ нарт даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 124

Номгон

Г

Г

Монгол Улсын Гавьяат жүжигчин цолоор  
шагнуулах хүний тодорхойлолт  
өргөн мэдүүлэх тухай

Баянхонгор аймгийн Богд сүүлийн уугуул Ширмэнгийн Наранчимэгийн Монгол Улсын Гавьяат жүжигчин цолоор шагнуулэх аар ирүүлсэн материалтай танилцаад ТЭМДЭГЛЭХ нь:

Ширмэнгийн Наранчимэг нь 1999 онд Хөгжим бүжгийн коллеж, 2003 онд Соёл урлагийн их сургуулийг дуурийн дүулаач мэргэжлээр МУГЖ А.Бүтэдийн удирдлаган дор суралцаж төгссөн. Италийн Ром хотын Санта Чечила консерватурт 2006 онд мэргэжил дээшлүүлсэн. 2003 оноос өнөөг хүртэл Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрт гоцпол дуучнаар ажиллаж байна.

Тэрээр А.Моцарт “Дон Жуа I” дуурийн Донна Эльвира, “Шидэт Лимбэ” дуурийн Папагена, Ж.Верди “Риголетто” дуусийн Паж, “Трубадур” дуурийн Леонара, “Аида” дуурийн Аида, “Реквием”, “Травиата” дуурийн Аннина, Ж.Штраус “Сарьсан баагваахай” опереттын Розалинда, Ж.Бизе “Кармен” дуурийн Мерседес, Ж.Пуччини “Богема” дуурийн Мюзетта, Ж.Пуччини “Тоска” дуурийн Тоска, Х.Билэгжаргал “Ламбугуайн нулимс” дуурийн Цэрэнлхам, Лувсаншарав “Хан Б'ргэд” дуурийн Норовлхам, Б.Дамдинсүрэн “Учиртай гурван толгой” дуурийн Нансалмаа, “Жаргалын зам” дуурийн Дулмаа, Б.Шарав “Чингис хаан” дуурийн Бөртэ, Хадаан, Ц.Нэцагдорж “Үүлэн заяа” дуурийн Наранзэл, Л.Мөрдорж “Хөхөө Намжил” дуурийн Уянга зэрэг дэлхийн сонгодог болон үндэсний олон дуурийн гол болон туслах дүрийг бүтээжээ.

Тиймээс хүн төрөлхтөний оюун ухааны их ай савын шим мандал нь шилмэл урлаг буюу сонгодог урлаг билээ. Энэхүү дэлхийн гайхамшигт урлаг Монголын хэмээх төрхөө олж, цагийн уртад төгөлдөржин ирснээр өнөөдөр бид Монголын Сонгодог урлаг хэмээн гайхуулах болсон. Монголын хэмэх тодотголтой сор болсон бүтээлүүдийн шилдэг ари, романс болон томосхон хэмжээний гайхамшигтай аялгуунуудыг үзэгч, сонгодог урлагийг шимтэн үзэгсдэд хүргэж Соёл урлагийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулж буй Ш.Наранчимэгийг Монгол Улсын Гэвъяат жүжигчин цолоор шагнуулах саналыг дэмжих нь зүйтэй.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Монгол Улсын Соёл, урлаги ін салбарын хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ сруулж, олон жил, үр бүтээлтэй ажиллаж ёайгаа Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрын гоцпол дуучин Ш.Наранчимэгийг Монгол Улсын Гавьяат жүжигчин цол тэмдгээр шагнуулахаар дэмжиж Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.





**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2016 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 125

Номгон

Баянхонгор аймгийн Ардын /Хөдөлмөрчдийн/ депутатуудын хурал түүний гүйцэтгэх захиргаа. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын 75 жилийн түүх бичих ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.11 дэх заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын ахмадын байгууллагын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Ардын /Хөдөлмөрчдийн/ депутатуудын хурал түүний гүйцэтгэх захиргаа, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын 75 жилийн түүх бичих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Батжаргал-Аймгийн Засаг дарга

Ажлын хэсгийн орлогч дарга: Ц.Дашцэрэн-Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: С.Үнэнбуюян-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Гишүүд: В.Эрдэнэчимэг-Аймгийн Төрийн архивын тасгийн дарга

Ч.Амгалан-Ахмад насттан

Ч.Гомбодорж-Ахмад насттан

Ц.Нарантуяа-Ахмад насттан

Л.Пүрэвгял-Ахмад насттан

2. Түүх бичих ажлыг 2017 оны 07 дугаар сард багтаан дуусгаж, 1000 хувь хэвлүүлсугэй.

3. Түүх бичих хэвлүүлэхтэй холбогдон гарах зардал 25000000 /хорин таван сая/ төгрөгийг 2016 оны төсвийн тодотоо алд оруулсан батлуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Д.ОТГОНБАЯР

116121



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 126

Номгон

Г Монгол Улсын “Гавьяат” цол,  
Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах  
хүмүүсийн тодорхойлолт өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

**МОНГОЛ УЛСЫН “ХҮНИЙ ГАВЬЯАТ ЭМЧ” ЦОЛООР**

1. Дагвуун Бүрнээ	Баянхонгор сум Шаргалжуут “Ганууд” эмнэлгийн их эмч
МОНГОЛ УЛСЫН “ГАВЬЯАТ МАЛ ЗҮЙЧ” ЦОЛООР	

1. Амгаагийн Хүрэлсүх	Бөмбөгөр сумын ахмад мал зүйч
-----------------------	-------------------------------

**“АЛТАН ГАД АС ОДОН”-ГООР**

1. Рэнжингийн Цэнд-Аюуш	Номуналай цогцолбор сургуулийн багш
2. Сангинаамдагийн Тогоомөн	Хөгжимт драмын театрын найруулагч
3. Дэмбэрэлийн Цэцгээ	Өлзийт сумын сургуулийн ахмад багш
4. Сэр-Одын Сономцэрэн	Өлзийт сумын сургуулийн ахмад ажилтан
5. Лхагвуун Должин	Өлзийт сумын сургуулийн ахмад багш
6. Сэрээхүүгийн Лхамдинмаа	Өлзийт сумын сургуулийн ахмад багш
7. Жамбын Цэрэндэгд	Өлзийт сумын сургуулийн ахмад багш
8. Цэдэвийн Жаргал	Өлзийт сумын сургуулийн ахмад ажилтан
9. Цэрэнпилийн Оюун	Өлзийт сумын цэцэрлэгийн ахмад багш
10. Бадарчийн Бэрцэцэг	Өлзийт сумын цэцэрлэгийн ахмад багш
11. Цэрэнпилийн Амгалан	Өлзийт сумын соёлын төвийн эрхлэгч
12. Бат-Очирын Лхагвадорж	Өлзийт сумын соёлын төвийн ахмад ажилтан
13. Должингийн Эрдэнэчимэг	Өлзийт сумын ахмад номын санч
14. Чулууны Баярсайхан	Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
15. Сааралын Цэцэгмаа	Номгон ахлах сургуулийн химиин багш

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-ИАР

- |                                        |                                            |
|----------------------------------------|--------------------------------------------|
| 16. Цэвэлээгийн Амартунгалаг           | Хөгжимт драмын театрын гоцпол бүжигчин     |
| 17. Сэр-Одын Баатархуяг                | Хөгжимт драмын театрын бүжигчин, жужигчин  |
| 18. Бямбын Дэлгэрмаа                   | Хөгжимт драмын театрын гоцпол хөгжимчин    |
| 19. Сүхбаатарын Ганчимэг<br>байгуулагч | Хөгжимт драмын театрын менежер, зохион     |
| 20. Борын Эрдэнэчимэг                  | Эрдэм ахлах сургуулийн физикийн багш       |
| 21. Пүрэвдоржийн Лхайезм               | Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн багш |
| 22. Цэрэнгийн Уранчимэг                | Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн багш |
| 23. Лхагважавын Сарангэрэл             | Номгон ахлах сургуулийн гадаад хэлний багш |
| 24. Шомбонгийн Лхамноржин              | “Унага трейд” ХХК-ний менежер              |

